

ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2012 оны 6-р сарын 13-ны байдлаар*


2012 оны 6-р сарын 13-ны байдлаар гол нэрийн барааны үнийг дүнгээр нь өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 0.7 хувь, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 0.8 хувиар буурсан байна.

Махны дундаж үнэ: 2012 оны 6-р сарын 13-ны байдлаар өмнөх 5-р сарын дундаж үнэтэй харьцуулахад үхрийн махны үнэ 2.0-6.8 хувь, адууны махны үнэ 4.7 хувь, ямааны махны үнэ 7.1 хувиар тус тус өссөн бол, хонины махны үнэ 2.3 хувиар буурсан байна.

Өмнөх 7 хоногийн үнэтэй харьцуулахад үхрийн махны үнэ 1.7-2.2 хувь, адууны махны үнэ 0.9 хувь, ямааны махны үнэ 3.5 хувиар өссөн бол, хонины махны үнэ 1.8 хувиар буурсан байлаа.

2012 оны 6-р сарын 13-ны байдлаар 1 кг хонины /ястай/ махны үнэ дунджаар 7022 төгрөг, үхрийн мах /ястай/ – 8281 төгрөг, ямааны мах - 5925 төгрөг, адууны мах – 6471 төгрөг, хонины цул мах – 7942 төгрөг, үхрийн цул мах – 9306 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1; 2).

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ **Зураг 2.** Цул махны жижиглэн худалдааны дундаж үнэ




Гурилын үнэ: 2012 оны 6-р сарын 13-ны байдлаар гурилын үнэ өмнөх 5-р сарын дундаж үнэтэй харьцуулахад “Алтан тариа” ХК-ны савласан дээд гурилын үнэ 1.6 хувь, задгай 1-р зэргийн гурил 1.9 хувиар буурсан байна.

Өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад “Алтан тариа” ХК-ны савласан дээд гурилын үнэ 0.6 хувиар буурсан бол, задгай 1-р зэргийн гурилын үнэ тогтвортой байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2012 оны 6-р сарын 13-ны байдлаар элсэн чихрийн үнийг өмнөх 5-р сарын үнэтэй харьцуулахад 2.0 хувиар өссөн бол, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.

Цагаан будааны үнийг өмнөх 5-р сарын дундаж үнэтэй болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 1.7 хувиар өссөн байна (Зураг 3).

Зураг 3



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2012 оны 6-р сарын 13-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх 5-р сарын дундаж үнэтэй харьцуулахад луувангийн үнэ 38.3 хувь, байцааны үнэ 36.9 хувь, сонгины үнэ 1.2 хувиар өсчээ. Төмсний үнэ тогтвортой байлаа.

Өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад байцааны үнэ 0.8 хувь, луувангийн үнэ 2.7 хувь, сонгины үнэ 3.3 хувиар өсчээ. Төмсний үнэ тогтвортой байна.

Сүү, өндөг, ургамлын тос, цэцгийн тосны дундаж үнэ: 2012 оны 6-р сарын 13-ны байдлаар өмнөх 5-р сарын дундаж үнэтэй харьцуулахад задгай сүүний үнэ 14.7 хувь, 1 литрийн савлагаатай сүүний үнэ 14.8 хувь, 0.5 литрийн савлагаатай сүүний үнэ 8.8 хувиар буурчээ.

Өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад харьцуулахад задгай сүүний үнэ 3.6 хувиар өссөн бол, 1 литрийн савлагаатай сүүний үнэ 9.1 хувь, 0.5 литрийн савлагаатай сүүний үнэ 2.0 хувиар буурсан байна.

Ургамлын тосны үнийг өмнөх 5-р сарын үнэтэй болон, өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад 2.0 хувиар буурсан байв.

Цэцгийн тосны үнийг өмнөх 5-р сарын дундаж үнэтэй харьцуулахад 21.5 хувь, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 21.2 хувиар буурсан байна.

Хүнсний гол нэрийн барааны үнэ, аймгаар

Хүнсний гол нэрийн барааны 7 хоногийн үнийн судалгаанд аймгийн төвүүдээс гурил, хонь, ямаа, үхрийн мах, цагаан будаа, шингэн сүү, элсэн чихрийн үнийг судалдаг (Хавсралт хүснэгт 3).

Гурилын үнэ: 2012 оны 6-р сарын 13-ны байдлаар аймгийн төвүүдийн хүнсний зах, дэлгүүрт хэрэглээ ихтэй 1-р зэргийн гурилын үнэ 600-950 төгрөгийн хооронд худалдаалагдсан байна. Гурилын үнэ өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад Баян-Өлгий, Дорноговь аймагт 20-50 төгрөгөөр өссөн бол, Төв аймагт 40 төгрөгөөр буурсан байна.

Баян-Өлгий аймагт 1-р зэргийн гурилын үнэ хямд буюу 600 төгрөг байхад, Хөвсгөл аймагт 950 төгрөг байгаа нь өндөр үнэ байлаа.

Махны үнэ: 2012 оны 6-р сарын 13-ны байдлаар хонины махны дундаж үнэ өмнөх 7 хоногийнхоос Баян-Өлгий, Өвөрхангай, Дорноговь, Увс, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар аймагт 50-800 төгрөгөөр өссөн бол, Говь-Алтай, Баянхонгор, Орхон, Дундговь аймагт 100-500 төгрөгөөр буурсан байна. Хонины махны үнэ 5500-7500 төгрөгийн хооронд худалдаалагдсан байна. Хонины махны үнэ Булган, Хөвсгөл аймагт 7500 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ байгаа бол, Баянхонгор аймагт 5500 төгрөг байна.

Үхрийн махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Баян-Өлгий, Завхан, Увс, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Сүхбаатар аймагт 50-800 төгрөгөөр өссөн бол, Орхон аймагт 300 төгрөгөөр буурчээ. Үхрийн махны үнэ Дорноговь аймагт 8300 төгрөг буюу хамгийн өндөр үнэтэй байхад, Увс аймагт 6500 төгрөг байгаа нь хамгийн хямд үнэ байна.

Ямааны махны үнэ Баян-Өлгий, Дундговь, Дорнод, Сүхбаатар аймагт 100-500 төгрөгөөр өссөн бол, Баянхонгор, Говь-Алтай, Хөвсгөл аймагт 100-700 төгрөгөөр буурсан байна. Ямааны махны үнэ Говь-Алтай аймагт 4800 төгрөг байхад, Хөвсгөл аймагт 6900 төгрөг буюу хамгийн өндөр үнэтэй байна.

Малын сүүний үнэ: 2012 оны 6-р сарын 13-ны байдлаар малын сүү аймгуудад 650-1800 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна. Сүүний үнэ Говьсүмбэр аймагт 200 төгрөгөөр өссөн бол, Баянхонгор, Булган, Дархан-Уул, Дорноговь, Төв, Сүхбаатар аймагт 50-300 төгрөгөөр буурчээ.

Цагаан будаа, элсэн чихрийн үнэ: 2012 оны 6-р сарын 13-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх долоо хоногийнхтой харьцуулахад Өмнөговь, Говьсүмбэр аймагт 100 төгрөгөөр өссөн байна. Аймгуудад цагаан будаа 1 кг нь 1400-2000 төгрөгөөр зарагдаж байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх долоо хоногийнхтой харьцуулахад бүх аймагт тогтвортой байна. Аймгуудад элсэн чихэр 1 кг нь 1500-1800 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.